

## Зээлийн тайлан

2016 оны 2 дугаар улирал

Нийт зээлийн үлдэгдэл өмнөх улирлаас 1.6 хувиар буюу 185.2 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 0.6 хувь буюу 67.8 тэрбум төгрөгөөр тус тус өсч 11.9 их наяд төгрөгт хүрчээ. Үүнээс татан буугдсан<sup>1</sup> банкуудын зээлийг хасч тооцвол нийт үлдэгдэл 11.7 их наяд төгрөг байгаа нь өмнөх улирлаас 1.4 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 0.3 хувиар өссөн үзүүлэлт юм.

Харин банкуудаас Монголын Ипотекийн Корпорацид шилжүүлсэн<sup>2</sup> зээлийн багцыг оруулж тооцвол зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 5.8 хувийн өсөлттэй байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудаар авч үзвэл хэрэглээний, цалингийн болон тэтгэврийн зээл нийт зээлийн үлдэгдлийн 27.4 хувь, худалдааны салбар 14.9 хувь, үл хөдлөх хөрөнгийн салбар<sup>3</sup> 13.8 хувь, барилгын салбар 11.6 хувь, боловсруулах үйлдвэрлэл 10.9 хувь, уул уурхайн салбар 7.4 хувь, бусад салбарууд 14.0 хувийг тус тус эзэлж байна.


Нийт зээлийн үлдэгдлийн 77.7 хувь нь төгрөгийн, 22.3 хувь нь валютаар олгогдсон зээл байгаа бөгөөд хөдөө аж ахуйн зээл, орон сууцны ипотекийн зээл, хэрэглээний зээл төгрөгөөр түлхүү олгогдож байгаа бол уул уурхай, мэдээлэл холбоо, санхүү даатгал, боловсролын салбарт валютын зээл давамгайлж байна.

<sup>1</sup> Зоос, Хадгаламж банк.


<sup>2</sup> МИК-д шилжүүлсэн 2.2 их наяд төгрөгийн зээлийн дүн нь банкны салбарын үзүүлэлтээс хасагдаж, бусад санхүүгийн байгууллагын үзүүлэлтэд тусгагддаг.

<sup>3</sup> МИК-д шилжүүлсэн орон сууцны ипотекийн зээлийг хассанаар


Зураг 1. Зээлийн үлдэгдэл



Зураг 2. Зээлийн үлдэгдэл /гол салбараар/



Зураг 3. Зээлийн үлдэгдэл /төгрөг, валютаар/




Зээлийн жилийн өөрчлөлт сүүлийн 4 улирлын турш сөрөг үзүүлэлттэй байсан бол тайлант улиралд өнгөрсөн оны мөн үеэс 3.5 нэгж хувиар өсч, жилийн өсөлт нь 0.6 хувьд (МИК-д шилжүүлсэн багцыг хассанаар) хүрч эерэг үзүүлэлттэй гарлаа. Худалдааны салбар болон хэрэглээний зээл өссөн, боловсруулах үйлдвэрлэлийн болон барилгын салбарын зээл олголт харьцангуй тогтвортой байгаа зэрэг нь нийт зээлийн өсөлт эерэг үзүүлэлттэй гарахад нөлөөлсөн байна. Харин уул уурхай болон хөдөө аж ахуйн салбарын зээлийн үлдэгдэл өнгөрсөн оны мөн үеэс дундажаар 17.5 хувиар буурсан байна.


Тайлант улиралд банкууд нийт 3 их наяд 239.8 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. Шинээр олгосон зээл өмнөх улирлаас 41.4 хувь буюу 949.1 тэрбум төгрөгөөр, өнгөрсөн оны мөн үеэс 28.5 хувь буюу 717.9 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ.

Шинээр олгосон зээлийг салбаруудаар авч үзвэл 1 их наяд 215.5 тэрбум төгрөг буюу 37.5 хувийг хэрэглээний зээлд, 735.6 тэрбум төгрөг буюу 22.7 хувийг бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 330.1 тэрбум төгрөг буюу 10.2 хувийг орон сууцны ипотекийн зээлд, 208.8 тэрбум төгрөг буюу 6.4 хувийг боловсруулах салбарт, 135.6 тэрбум төгрөг буюу 4.2 хувийг барилгын салбарт, 38.8 тэрбум төгрөг буюу 1.2 хувийг уул уурхайн салбарт тус тус олгожээ.


**Зураг 4. Зээлийн жилийн өсөлтийн задаргаа /гол салбараар/**



**Зураг 5. Олгосон ба төлөгдсөн зээл**



**Зураг 6. Олгосон зээл /салбараар/**




Тайлант улиралд олгосон зээлийн 37.1 хувийг 1 жил хүртэлх хугацаатай, 50.4 хувийг 1-5 жилийн хугацаатай, 12.5 хувийг 5 жилээс дээш хугацаатай олгосон бөгөөд, 1-5 хүртэл жилийн хугацаатай зээлийн хувийн жин өмнөх оны мөн үеэс 8.3 нэгж хувиар нэмэгдсэн бол 1 жил хүртэл хугацаатай зээлийн хувийн жин 7.9 нэгж хувиар, 5-аас дээш жилийн хугацаатай зээлийн хувийн жин 0.4 нэгж хувиар тус тус буурсан байна.

Тайлант улиралд 2 их наяд 884.9 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдсөн нь өмнөх улирлаас 29.9 хувь буюу 664.4 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 10.2 хувь буюу 267.2 тэрбум төгрөгөөр тус тус багассан байна. Нийт зээлийн үлдэгдлийн 84.4 хувь нь хугацаандаа байгаа зээл, 6.9 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, 8.6 хувь нь чанаргүй зээл байна.


Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 226.3 тэрбум төгрөгөөр өссөн бол өмнөх улирлаас 134.9 тэрбум төгрөгөөр буурч 828.0 тэрбум төгрөгт хүрсэн байна. Чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 260.1 тэрбум төгрөг буюу 33.6 хувиар, өмнөх улирлаас 68.4 тэрбум төгрөг буюу 7.1 хувиар өсч 1 их наяд 32.1 тэрбум төгрөгт хүрчээ. Харин татан буугдсан Зоос, Хадгаламж банкуудын чанаргүй зээлийг хасч тооцвол нийт зээлд эзлэх чанаргүй зээл 6.6 хувь байна.

Гол салбарууд дахь чанаргүй зээлийн хувь хэмжээг /Зоос, Хадгаламж банкуудыг хассанаар/ авч үзвэл уул уурхайн олборлолтын салбарт 28.4 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 9.9 хувь, хөдөө аж ахуйн салбарт 7.5 хувь, бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт 6.6 хувь, барилгын салбарт 5.3 хувь байна. Харин


Зураг 7. Олгосон зээл /хугацааны ангиллаар/



Зураг 8. Чанаргүй зээлийн хэмжээ ба өөрчлөлт



Зураг 9. Чанаргүй зээл, хугацаа хэтэрсэн зээл /тухайн салбартаа эзлэх хувиар/




хугацаа хэтэрсэн зээлийн хувьд уул уурхайн салбарт 41.6 хувь, барилгын салбарт 11.3 хувь, хөдөө аж ахуйн салбарт 10.7 хувьтай байна. Нийт банкны салбарын чанаргүй зээлийн 26.9 хувийг уул уурхайн салбар, 16.5 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбар, 14.2 хувийг худалдааны салбар, 9.3 хувийг барилгын салбар, 11.6 хувийг бусад салбаруудын чанаргүй зээл бүрдүүлж байна.

Хувийн хэвшил, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл банкны салбарын зээлийн 98.9 хувийг бүрдүүлжээ. Хувийн хэвшлийн зээлийн үлдэгдлийн 21.0 хувийг бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 19.8 хувийг барилгын салбарт, 18.7 хувийг боловсруулах үйлдвэрийн салбарт, 12.6 хувийг уул уурхайн салбарт, 27.9 хувийг бусад салбарт тус тус олгожээ.


Иргэдийн зээлийн үлдэгдлийн 51.0 хувийг орон сууцны ипотекийн зээл (МИК-д шилжүүлсэн зээлийг оруулснаар) бүрдүүлж байгаа бол 39.0 хувийг цалингийн зээл, хадгаламж барьцаалсан зээл, картын зээл, тэтгэврийн зээл болон бусад хэрэгцээнд зориулсан зээл, 5.1 хувийг бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 4.9 хувийг бусад салбарт тус тус олгосон байна.

Иргэдэд олгосон зээлийн үлдэгдлийн жилийн өөрчлөлт тайлант улиралд буурсан үзүүлэлттэй байгаа бол сүүлийн 4 улирал дараалан буурсан хувийн хэвшлийн зээлийн үлдэгдэл тайлант улиралд өссөн дүнтэй байна. Тухайлбал, хувийн байгууллагын зээлийн жилийн өсөлт 3.9 хувьтай байгаа бол иргэдийн зээл 3.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Харин өмнөх улирлын зээлийн үлдэгдэлтэй харьцуулахад иргэдийн зээл 4.4 нэгж хувиар нэмэгдсэн байна. МИК-д шилжүүлсэн зээлийн багцыг оруулж тооцвол иргэдийн зээл өмнөх оноос 7.5 хувиар өссөн байна.


**Зураг 10. Хувийн байгууллагын зээл**



**Зураг 11. Иргэдийн зээл**



**Зураг 12. Иргэд, хувийн хэвшилд олгосон зээлийн жилийн өсөлт**



Тухайн салбарт олгосон зээлийн үлдэгдлийг нийт зээлдэгчдийн тоонд харьцуулахад уул уурхайн салбар хамгийн өндөр (3 тэрбум 439 сая ₮) дүнтэй байгаа бол мэдээлэл холбоо (559.4 сая ₮), барилгын салбар (479.3 сая ₮) удаалж байна. Харин нийт зээлд өндөр хувь эзэлдэг худалдаа, орон сууцны ипотекийн зээлийн нэгж зээлийн хэмжээ 47.2-71.2 сая төгрөгийн хооронд, хэрэглээний зээлийн хувьд хамгийн бага дүнтэй буюу 4.2 сая төгрөг байна.


Тайлант улиралд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүүг салбараар авч үзвэл, тээвэр агуулах (19.7%), уул уурхайн салбар (18.8%) болон хэрэглээний зээл (18.6%) нь өндөр хувьтай байгаа бол худалдаа (13.3%), боловсруулах (15.2%), хөдөө аж ахуйн (17.0%) салбарт олгосон зээлийн хүү харьцангуй бага байна.

Банкуудын тайлант улиралд олгосон зээлийн жигнэсэн дундаж хугацаа<sup>5</sup> 23.3 сар байна.

Зураг 13. Нэгж зээлийн хэмжээ<sup>4</sup>




Зураг 14. Олгосон зээлийн хүү /салбараар/



**Иргэд, жижиг дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжид олгосон зээл**

Тайлант улиралд иргэдийн зээл 5 их наяд 205.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаагийн 30.2 хувь буюу 1 их наяд 570.7 тэрбум төгрөг нь ипотекийн, 26.9 хувь буюу 1 их наяд 400.0 тэрбум төгрөг нь цалингийн, 14.4 хувь буюу 748.5 тэрбум төгрөг нь жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх, 9.8 хувь буюу 508.9 тэрбум төгрөг нь тэтгэврийн, 6.0 хувь буюу 313.5 тэрбум төгрөг нь хэрэглээний, 12.8 хувь буюу

Зураг 15. Иргэдийн зээл /зориулалтаар/



<sup>4</sup> Уул уурхайн салбарыг тус дүрслэлд харуулаагүй

<sup>5</sup> Тайлант улиралд олгосон ОСИЗ-ийн жигнэсэн дундаж хугацааг хассанаар

663.7 тэрбум төгрөг нь бусад зээл байна.


Иргэдийн нийт зээлд эзлэх чанаргүй зээл 3.4 хувь байгаагаас хэрэглээний зээл 3.1 хувь, цалингийн зээл 2.3 хувь, ипотекийн зээл 2.3 хувьтай байна. Тэтгэврийн зээлийн эргэн төлөлт харьцангуй сайн байна.

Иргэдэд олгосон зээлийн дундаж хүү 16.7 хувь байгаа бөгөөд хэрэглээний (20.4%) болон цалингийн (20.5%) зээлийн хүү харьцангуй өндөр байна. Харин иргэдэд олгогдсон зээлийн дундаж хугацааны хувьд орон сууцны ипотекийн зээл 226.9 сар (18.9 жил), цалингийн зээл 30.8 сар (2.8 жил) байгаа бол тэтгэврийн зээлийн хувьд 4.1 сар байна.

Тайлант улиралд жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ) эрхлэх зориулалтаар аж ахуйн нэгж болон иргэдэд нийт 397.7 тэрбум төгрөгийн зээл олгож, тайлант улирлын эцэст нийт 45105 иргэд, 5232 аж ахуйн нэгжүүд 2097.6 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Үүнээс 35.7 хувь буюу 748.5 тэрбум төгрөг нь ЖДҮ эрхлэгч иргэдийн зээл, 64.3 хувь буюу 1349.0 тэрбум төгрөг нь ЖДҮ эрхлэгч аж ахуйн нэгжийн зээл байна. ЖДҮ-ийн зээлийг салбараар авч үзвэл худалдаа (33.1%) болон боловсруулах үйлдвэрлэлийн (22.9%) салбарт түлхүү олгогдсон байна.


ЖДҮ-ийн нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь 10.0 хувь байгаа бөгөөд үйлчилгээ, барилга, хөдөө аж ахуйн салбарын ЖДҮ эрхлэгч иргэдэд олгосон зээлийн чанаргүй зээлийн хувь харьцангуй өндөр байгаа бол худалдааны салбарт олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү харьцангуй бага байна.

Зураг 16. Чанаргүй зээлийн хувь /зориулалтаар/




	Зээлийн дундаж хүү /хувь/	Зээлийн дундаж хугацаа /сар/
Иргэдийн зээл	16.7%	60.6
Ипотекийн зээл	8.1%	226.9 (18.9 жил)
Хэрэглээний зээл	20.4%	14.9
Цалингийн зээл	20.5%	30.8 (2.6 жил)
Тэтгэврийн	18.0%	4.1
Бусад зээл	17.5%	12.9

Зураг 17. ЖДҮ-ийн зээлийн хэмжээ /салбараар/



Зураг 18. ЖДҮ-ийн чанаргүй зээлийн хувь



ЖДҮ эрхлэгчдэд олгож буй зээлийн дундаж хүү болон хугацааг харьцуулахад иргэдэд олгогдож буй зээлийн хүү (24.3%) харьцангуй өндөр, урт хугацаатай (28.2 сар) байгаа бол ААН-ийн зээлийн хүү бага (18.7%), харин дундаж хугацаа нь богино (23.9 сар) байна.

Зураг 19. ЖДҮ-ийн зээлийн хүү, хугацаа

